

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 12/370

НШУС

2011

ЭКОЛОГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ БА ЦӨЛЖИЛТИЙН СЭДЭВ

Ч.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: экологийн сэтгүүл зүй, байгаль орчин, сэдэв, цөлжилт, ОНМХ, нийтлэлийн давтамж, шийдвэрлэх арга зам.

Хүн, байгаль хоёрын харилцаа өргөжин тэлсэн XX зууны сүүл-XXI зууны эхэнд экологийн сэдэв баяжсан нь арга ч үгүй юм. Урьд нь зөвхөн ой мод, ховор ан амьтны нөөцийн тухай бичдэг байсан бол өдгөө манай тогтмол хэвлэлд дээрхээс гадна байгалийн гамшиг, тогтвортой хөгжил, цөлжилт, экологийн эрх зүй, агаар, усны бохирдол, бэлчээрийн асуудал, хөрсний доройтол зэргийг олон арван сэтгүүлч, нийтлэлч хэмжээгээр тусгаж байна.

Гэвч асуудлын тоон үзүүлэлтийг авч үзвэл чамлалттай дүр зураг гарч ирнэ. Манай өдөр тутмын хэвлэлүүд экологийн сэдэвт хэр ач холбогдол өгч байгааг сонирхъя. Өдөр тутмын хэвлэлүүдийн 2005 оны 11-р сарын дугааруудад агуулгын задлан шинжилгээ хийхэд «Зууны мэдээ» сонин ашигтай талбайнхаа (үүнд реклам, зар, PR мэдээллийг хамруулаагүй болно) 3,5%, «Улаанбаатар The Times», «Ардын

эрх» тус бүр 2,8%, «Үнэн», «Өнөөдөр» тус бүр 2,5%, «Монголын мэдээ» 2%, «Өдрийн сонин» 1,9%, «Өнөөдрийн Монгол» 0,5%-ийг байгаль орчны сэдэвт зарцуулдаг байна. Энэ бол үнэхээр чамлалттай үзүүлэлт юм. Өдөр тутмын хэвлэлүүд өдөрт нийтдээ 100 нүүрээр хэвлэгдэж байна гэж бодвол үүнээс ердөө 2,3 нүүр л экологийн сэдэвт зарцуулагдаж байна гэсэн үг билээ.

Сүүлийн жилүүдэд сэтгүүлч, нийтлэлчид байгаль орчны сэдвийг хөндөх нь 1990-ээд оны эхний хагасыг бодвол нэмэгджээ. Гэхдээ нийт материалын тоотой харьцуулж үзвэл экологийн сэдэвтэй нийтлэлийн давтамж хангалтгүй бөгөөд бидний хийсэн тооцоогоор ердөө 3-5 хувийг эзэлж байна.

Харин дээр дурдсанчлан, сэдвийн хүрээ сүүлийн жилүүдэд нилээд өргөжсөн юм. 1980-аад оны «Үнэн», 1990-ээд оны «Ардын эрх», «Засгийн газрын мэдээ», 2000-аад оны «Өдрийн сонин», «Зууны мэдээ» сонины экологийн сэдэвт нийтлэлүүдийг дотор нь задалж үзвэл дараах дүр зураг бууж байна¹:

Сэдэв	1980-аад он	1990-ээд он	2000-аад он
Мод, ойн нөөцийн хомсдол	27.6%	13.2%	10.0%
Байгалийн шинжлэл	22.5%	1.0%	7.0%
Ус, усны бохирдол	13.8%	4.3%	4.0%
Ан, амьтан	13.6%	26.4%	18.7%
Дархан цаазат газар	9.0%	5.4%	1.8%
Цөлжилт	7.2%	2.8%	2.8%

Бэлчээрийн даац, хөрсний бохирдол	2.9%	0%	0.6%
Алт, ашигт малтмал	1.2%	21.3%	5.8%
Байгаль хамгаалал	1.4%	20.5%	25.2%
Хог хаягдал	0.4%	0%	2.8%
Агаарын бохирдол	0.4%	2.0%	6.0%
Байгаль цаг уурын өөрчлөлт	0%	0.6%	2.4%
Байгалийн гамшиг	0%	2.5%	12.9%
Нийт	100%	100%	100%

Байгаль орчны асуудлуудаас сүүлийн жилүүдэд манай оронд төдийгүй, дэлхий дахинаа хамгийн ихээр тулгамдаад байгаа цөлжилтийг сугалан авч, энэ эгзэгтэй сэдвийг тусгасан нийтлэлүүдэд агуулгын задлан шинжилгээ хийлээ. Тэгэхдээ энэ сэдвийг цаашид үнэн бодитой, алдаа мадаггүй тусгахад дөхөм болох үүднээс нийтлэлүүдэд шүүмжлэлтэй хандахыг урьтал болголоо. Эдгээр алдаа дутагдлыг экологийн сэдэвт нийтлэлийн онцлог шинж тус бүр задлан шинжлэхийг хичээсэн болно.

Экологийн сэдвийн тодорхойгүй байдал

Экологийн сэдвээр даалгавар авсан тусгай бэлтгэлгүй сэтгүүлчдэд тулгардаг гол бэрхшээлийн нэг бол тодорхойгүй байдал юм. Учир нь эрдэмтэд байгаль орчны ямар нэг асуудлын талаар нэг мөр ойлголтгүй, түүгээр барахгүй эсрэг тэсрэг үзэл бодолтой байдаг. Энд ганц-хоёр жишээ авъя. Сүүлийн үед манайд багагүй маргаан дэгдээж буй асуудлын нэг бол бэлчээр юм. Монголын эрдэмтдийн нэг хэсэг нь бэлчээрийн тэжээлийн жилийн дундаж нөөц нь хонинд шилжүүлбэл 70 хүртэл сая орчим малд хүрэлцэнэ, харин манай улсын нийт малыг хонинд шилжүүлбэл 67,2 сая болно, энэ нь бэлчээрийн даац хүрэлцээтэй гэсэн үг гэж үздэг. Гэтэл нөгөө хэсэг нь малын тоо толгой бэлчээрийнхээ даацаас хэтэрчихээд байгаа, хонинд шилжүүлснээр 58 сая толгой бол дээд хэмжээ, тиймээс байгаль нь зуд, гангаар өөрөө зохицуулж байна, үүнээс сэргийлэхийн тулд малын тоо толгойн өсөлтөд

хяналт тавихгүй бол болохгүй, тоог бус, чанарыг чухалчлах цаг ирсэн гэдэг.

Өөр нэг жишээ. Манай орны хувьд 1990 оноос өмнө нийт нутаг дэвсгэрийн 15 хувийг ой мод эзэлж байсан бол өдгөө энэ тоо хоёр дахин, магадгүй түүнээс ч илүү буурсан байж болзошгүй гэдэг. Судалгааны ажлуудад харилцан адилгүй (6,7%, 7%, 8% г. м.) тоо заах тохиолдол цөөнгүй. Тэгвэл 1% гэж юу вэ? Энэ бол Монголын хувьд 15641 км² газар. Энэ газар нутаг дээр Люксембург, Коморын арлууд, Маврикий, Доминика, Тонга, Кирибати, Микронези, Сингапур, Бахрейн, Сент-Люсия, Андорра, Палау, Сейшелийн арлууд, Антигуа ба Барбуда, Барбадос, Сент-Винсент ба Гренадин, Гренада, Мальта, Мальдивийн арлууд, Сент-Китс ба Невис, Лихтенштейн, Сан-Марино, Тувалу, Науру, Монако зэрэг 25 арлын болон хот улс багтана. Ямартаа ч эдгээр «улс»-ад 10 сая 580 мянган хүн аж төрж байна.

Гэтэл эрдэмтэд байгаль орчны олон асуудлаар зөрүүтэй байр суурьтай байдгаас болж экологийн сэдвийн тодорхойгүй байдал үүсэхээс гадна экологийн асуудлаар сэтгүүлчид буруу зөрүү ойлголт авсан, баримтуудыг дутуу дулимаг боловсруулсан зэргийн уршгаар уншигчдад андуу ташаа мэдээлэл дамжуулдаг. Тухайлбал, цөлжилтийн тухай өгүүлүүдийг уншиж байхад эндүү зөрүү баримт олонтаа тулгардаг. Нэг бол Монгол Улсын нийт газар нутгийн, нэг бол бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтолд нэрвэгдэх магадлалтай гэдэг. Гэтэл нэрвэгдчихсэн мэтээр бичсэн ч байдаг. Ерөнхий

тооны сацуу нарийвчлан задалсан нь ч бий. «Үнэлгээ, зураглалын өнөөгийн үр дүнгээр цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэлд 5.0 хувь, хүчтэй зэрэглэлд 18.0 хувь, дунд зэрэглэлд 26.0 хувь, сул зэрэглэлд 23.0 хувь нь тус тус хамрагдах болжээ. Энэ нь тодорхой бүс нутагт цөлжилтийн аюулын зэрэглэл нэмэгдэж, нутаг дэвсгэрийн 72 хувь хүртэл өргөжсөн байгааг харуулж байна» гэж бичсэнийг уншвал цөлжилт 72%-д хүрсэн гэж ойлгож ч болохоор байна.

Өөр өгүүлүүдэд: «Албан ёсны тоо баримтаар Монголын нийт нутгийн 40 гаруй хувь, албан бус тооцоогоор түүнээс ч их хувь нь цөлжилтөд нэрвэгдээд байна», «Яг одоогийн байдлаар манай орны нийт нутаг дэвсгэрийн 80-аад хувь нь цөлжилтөд их, бага хэмжээгээр өртжээ» гэж бичжээ. Тэгэхээр цөлжилтийн тухай тогтмол хэвлэл, веб сайтуудад гарсан мэдээлэлтэй танилцсан уншигч ямар нэг цэгцтэй ойлголт авах ямар ч боломжгүй юм.

Энэ бүх тоо баримтыг хэрхэн ойлговол зохих вэ? гэдэг асуулт урган гарах нь тодорхой. Гамшгийн эсрэг үндэсний төвийн веб сайтад юу гэж бичсэнийг сонирхъя: «Монголын газар нутгийн 41,3 хувь нь говь цөл бөгөөд цөлжилт нийт газар нутгийн 76 хувьд сул, 20 хувьд дунд зэрэг, дөрвөн хувьд хүчтэй илэрсэн гэж үздэг. Нийт газар нутгийн 76,5 хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 96,2 хувь нь бэлчээрийн талбай байдаг атал эдүгээ түүний ихэнх хэсэг нь талхлагдаж, өвс ургамлын гарц буурч, тариалангийн талбайн 46 хувь нь үржил шимээ алдаж хөрсний доройтолд ороод байгаа юм».

Экологийн ээдрээтэй асуудлыг үнэн бодитой тусгахын тулд сэтгүүлч эхлээд өөрөө мөн чанарт нь нэвтэрсэн байх шаардлагатай нь эндээс харагдана. Түүнчлэн аливаа эх сурвалжийг ашиглахдаа тухайн судалгаа хийсэн байгууллагын чансааг харгалзаж, мөн

болж өгвөл хамгийн сүүлийн баримтыг түшиглэх хэрэгтэй юм.

Энэ буруу зөрүү мэдээлэл ямар уршигтай вэ? Байгаль орчны асуудал нь барьцгүй, хийсвэр болж, тулгамдсан бэрхшээлүүдтэй хийх тэмцэл, авах арга хэмжээнүүдийн эрч хүчийг сааруулах сөрөг талтай.

Сэтгэл хөдлөлийн өнгө аяс

Экологийн сэдэв сэтгүүл зүйн бусад сэдвээс (эдийн засгийн, анаагах ухааны г. м.) сэтгэл хөдлөлийн өнгө аясаар ялгардаг. Гэхдээ олон нийтийг айлгаж, зохиомол түгшүүр дэгдээхгүйн тулд сэтгүүлчид болгоомжтой бичих ёстой гэж заадаг, номлодог.

Айлгах бол экологийн нийтлэлийн зорилго биш. Гэтэл экологийн тулгамдсан асуудлын тухай бичихдээ сэтгүүлчид сэдвийнхээ ач холбогдлыг өсгөн нэмэгдүүлэхийн тулд уншигчдад айдас, түгшүүр төрүүлэхийг чухалчилдаг үзэгдэл амь бөхтэй байна.

Гарчгаас нь харахад л: «Бид хойч үедээ нэг ч модгүй нүүцэн хөх Богд Дунжингарав уул хүлээлгэн өгөх нь», «Цөлжилт Монголыг бүхэлд нь залгих нь» г. м. Ийм гарчиг экологийн сэдэвт нийтлэлд зохимжгүй гэж хэлэх гээгүй. Гол нь сүртэй үг, сүржин гарчгийн араас хөөцөлдөх бус, харин бичиж буй зүйлээ мэдэж байх нь зөв.

Сэтгэл хөдлөлийн зохимжгүй илрэлийн нэг хэлбэр нь цэцэрхэх юм. Энэ нь мөн л экологийн сэтгүүл зүйн үүрэг, зорилгод харш билээ. «Улаанбаатарын уушиг устжээ» («Зууны мэдээ», 2008.02.12) гарчгийг уншихад сэтгүүлч юуны тухай хэлэх гэснийг таамаглаж болно. Гэхдээ агаарын бохирдлоос болж нийслэлчүүд уушигны өвчтэй болж байгааг ингэж хэлэх хэр оновчтой вэ? «Загаснууд дахин "амиа хорлов"» («Зууны мэдээ», 2008.04.03) гарчиг дэндүү ёс зүйгүй болжээ. Амиа хорлов гэдэг үгийг хашилтанд хийж ёжлох шаардлага бий юу? гэдгийг сэтгүүлч төдийгүй, редакци бодолцох ёстой байсан. Оросын

судлаач Л.А.Кохановагийн оновчтой тэмдэглэснээр: «Сэтгүүлч мэдээлэл цуглуулахаар гараад хөдөө аж ахуйн салбарын ажилтантай ч, усны салбарын төлөөлөгчтэй ч өөрсдийнх нь ярьдаг тус тусын хэлээр харилцаж чадахгүй бол түүний буруу. Гэхдээ хэрэв сэтгүүлчийн бичсэн нийтлэл сонины хуудаснаа хэвлэгдээд гараад ирвэл энэ нь ганц түүний төдийгүй, тухайн дугаарыг бэлтгэсэн хамт олны хариуцлага мөн. Тиймээс нэр томъёо, гарчигт гарсан болон ... бусад алдаа мэдгийн хариуцлагыг тухайн хэвлэлийн сэтгүүлчдийн бүхий л хамт олон адилхан үүрэх ёстой»². Дээрх гарчгийн үйл үгийн хэвийг анхаарах хэрэгтэй. Амиа хорлох гэдэг нь өөрөө үлдэх хэв. Тэгвэл загас өөрөө өөрийгөө өгүүтгэсэн хэрэг үү? Аль эсвэл хүний буруутай үйл ажиллагаанаас болж, тодруулбал гадны нөлөөгөөр өөрийн жам ёсны орчиндоо үхсэн үү?

Энэ бүхнийг сэтгүүлч толгойдоо тунгаасны дараа цаасан дээр буулгах ёстой.

Идэвхгүй хандлага

Экологийн сэдвээрх ихэнх материал ямар нэг зүйлийн, тухайлбал: албан ёсны мэдэгдэл, эсвэл холбогдох байгууллагын тайлангийн дагавар болж нийтлэгддэг. Энэ бол идэвхгүй сэтгүүл зүй, идэвхгүй хандлагын тод жишээ юм. Яагаад гэвэл энэ нь ОНМХ-ээр юу тусгахыг хэн нэгэн хэлж, зааж өгч байна, сэтгүүлчдийг удирдаж, чиглүүлж байна гэсэн үг юм. Экологийн сэтгүүл зүй эрэн сурвалжлах сэтгүүл зүйтэй ойр байдгийн хувьд сэтгүүлч хэзээ, яаж, юу бичихээ өөрөө мэддэг байвал зохино.

Сэтгүүлчийн өөр нэг дутагдал нь нэг нийтлэл биччихсэн л бол тэр сэдвийг өөрийнхөө хувьд хаадаг. Гэтэл экологийн аль ч асуудал нэгийн зэрэг нийтлэл, ярилцлагаар нааштай шийдэгдчихдэггүй. Тиймээс сэтгүүлч байн байн өнөөх сэдэвтээ эргэж очиж, урьд өмнө бичсэнээсээ шинэ зүйлийг

эрэлхийлэн, өөрөө идэвх гаргах хэрэгтэй.

Идэвхгүй хандлагын өөр нэг илрэл нь тодорхой нэг үйл явдалтай тохиолдуулж сэдвийг сөхөх явдал юм. Тухайлбал, Дэлхийн ган, цөлжилттэй тэмцэх өдрийг тохиолдуулан тогтмол хэвлэл, веб сайтад мэдээлэл гараад нэг хэсэгтээ намждаг практик тогтчи-хоод байна.

Цөлжилтийн асуудлыг тусгахдаа гадаадын жишээ баримтаар булдаг, энэ нь Монголд төдийлөн холбогдолгүй мэт сэтгэгдэл төрүүлэхээр бичдэг дутагдал мэр сэр боловч үзэгдсээр байна. Тухайлбал: *«Цөлжилтийн өнөөгийн хурдаар бол 2025 онд дэлхийн хуурай газрын гуравны нэг нь цөлжиж, 2.3 тэрбум хvн цэвэр усны хомсдолд орохыг энэ салбарын эрдэмтэд тооцоолжээ. Энэ нь бидний монголчуудад ч хамаатай. Цөлжилт гэж юу байдгийн жишээ Сахарын цөлийг хvн бvхэн мэднэ»*³.

Дараагийн жишээ ОНМХ-тэй холбогдолгүй ч цөлжилт Монголд хамааралгүй мэт бичдэгийн нэг тод илрэл болох юм. Хамгийн өргөн мэдээлэлтэй цахим «Википедиа» нэвтэрхий толины монгол хувилбарын «Цөлжилт» өгүүллийг үзэхэд ганц гэрэл зураг байгаа нь «Намиби улс дахь Намибийн цөл» гэсэн тайлбартай. «Говь» хэмээх үг 2 удаа, «Монгол» хэмээх үг 1 удаа тохиолдож буй юм (*«Австрали болон Говьд явагдаж буй»*; *«Монгол улсын нутгийн өмнөд хэсэгт орших Говьд цөлжилт эрчимтэй явагдаж, цөлийн бүс нь хүрээгээ хойш тэлсээр буй»*.)

Эдгээрийн зэрэгцээ өөр нэг түгээмэл дутагдал бол экологийн асуудлын тухай өгүүлчихээд хаа нэгнээс (тухайлбал: Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хөдөлгөөн г. м.) авч буй арга хэмжээнүүдийг үгүйсгэх явдал юм. Тухайлбал: *«Монгол Улс Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ойн тухай үндэсний хөтөлбөр, Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр, Усны үндэсний хөтөлбөр,*

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр зэрэг 20 гаруй хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна. Гэвч үр дүн нь төдийлэн харагдахгүй байгаа нь харамсалтай»⁴.

«Бид хаа нэгтээ хурал зөвлөлгөөн хийж л цөлжилтөөс «хамгаалж» байна. Улаанбаатар, Нью-Йоркт хичнээн том хуралд суугаад байхад өнөө элсний нүүдэл зогсдоггүй нь гачлан-тай» (Чив чимээгүй аюул, «Ардын эрх», 1997.06.17).

Цөлжилт бол экологийн хамгийн ноцтой гамшгийн тоонд ордог. Учир нь 1 см үржил шим бүхий хөрсийг нөхөн сэргээхэд 70-150 жил шаардлагатай байдаг. Гэтэл бид тэр даруй үр дүн гарахыг тэсэн ядан хүлээж, ингэхгүй бол элдвээр шүүмжилдэг. Энд нэг жишээ дурдмаар байна. 1970-аад оноос БНХАУ-д Ногоон хэрэм босгож эхэлсэн. Энэ ажлыг 2050 он хүртэл үргэлжлүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь 13 мужийн нутгаар дамжсан, 4500 км урттай, 100 километрийн өргөнтэй мод, бут, сөөг, ургамлаас бүрдсэн хамгаалалтын бүс юм. Үүний үр дүнд 350 мянган км² газар нутгийг (Германы нутаг дэвсгэр) ногооруулах ажээ. Одоогийн байдлаар таригдсан мод жилд 200 сая тонн элсийг тогтоож байгаа гэсэн судалгаа бий. Энэхүү нүсэр төсөлд Хятадын ард түмэн тэр аяараа оролцож байна. 11-ээс 60 настай иргэн бүр жилийн дотор гурваас таван мод тарих, эсвэл зохих татвар төлөх үүрэгтэй⁵.

Гэтэл Засгийн газрын 2005 оны 5-р сарын 4-ний өдрийн хуралдаанаар «Ногоон хэрэм» Үндэсний хөтөлбөрийн батлагдсаныг тухайн үед шүүмжилж

байсан хэвлэл цөөнгүй. Нэг сэтгүүлч Байгаль орчны сайд У.Барсболдтой хийсэн «Биднээс хамаарах, хамаарахгүй хоёулангаас нь шалтгаалж цөлжилт үүсч байна» («Өдрийн сонин», 2005.10.18) гарчигтай ярилцлагаа бүхэлд нь улстөржүүлж, БОЯ-ыг үндэслэлгүй буруушааж шүүмжилсэн байдаг. Энд тэрхүү ярилцлагын ганцхан асуулыг л дурдъя: «"Ногоон хэрэм"-ийн үр

дүн аль вэ? Яармагийн замаар явдаг олон хүн хэдэн хатсан бургасыг зааж танай яамыг тавалцгаадаг?» «Ногоон хэрэм» гэдгийг сэтгүүлч Яармагийн зам дагуу тарьсан бургас гэж ойлгосон бололтой.

Тэгвэл өнөөдөр энэ хөтөлбөрийн ачаар ямартаа ч 2500 га газар модтой болоод байна.

«

Экологийн сэдвээрх ихэнх материал ямар нэг зүйлийн, тухайлбал: албан ёсны мэдэгдэл, эсвэл холбогдох

байгууллагын тайлангийн дагавар болж нийтлэгддэг. Энэ бол идэвхгүй сэтгүүл зүй, идэвхгүй хандлагын тод

жишээ юм. Яагаад гэвэл энэ нь ОНМХ-ээр юу тусгахыг хэн нэгэн хэлж, зааж өгч байна, сэтгүүлчдийг удирдаж, чиглүүлж байна гэсэн үг.

»

Шалтгааныг зөв дурдах

Цөлжилт маш олон шалтгааны үр дүнд үүсдэг үйл явц юм. Тэдгээрийг ерөнхийд нь хүний үйл ажиллагаатай холбоотой болон байгалийн хүчин зүйл хэмээн ангилдаг. Үүнээс хүний нөлөөлөл нь 87 хувь, байгалийн нөлөөлөл 13 хувь байдаг. Цөлжилтөд хүргэдэг хүчин зүйлүүдийг тодорхой дурдсан, жишээ баримтаар харуулсан нийтлэл цөөнгүй бий. Гэтэл үүний сацуу этгээд, гаж зүйл ч бичиж байна: «Яндаж болдоггүй далай шиг... Эх нутгаа бид ийнхүү магтан дуулна. Дуулаад л... Холхи газраас цуурайтан "дуулдах" "...изм"-ыг баримжаалан шуурхайлж явтал ар хормой доогуур нэгэн муу ёр нүүрлэх шинжтэй болов. Энэ бол цөлжилт. Даян дэлхийг сэрдхийлгэж байгаа энэхүү газрын "СПИД", тэрхүү их аюул Монголд нүүрлэх бүрэн магадлалтай

байна» (Чив чимээгүй аюул, «Ардын эрх», 1997.06.17).

Цөлжилт социализмаас болсон мэт сэтгүүлч өгүүлжээ. Социализм байгуулах гэж оролдоогүй бол Монголд цөлжилт нүүрлэхгүй байсан мэт... Уг нь «... изм», цөлжилт хоёр хоорондоо ямар ч харилцан хамааралгүй нэг нь улс төрийн, нөгөө нь байгалийн үзэгдэл. Цөлжилт бол цаг агаар дулаарах, гол мөрөн ширгэх, ой багасах, намагжих, хөрс хужиртах, хөрс элэгдэх, бэлчээрийн даац хэтрэх зэрэг цогц шалтгаанаас болж явагддаг үйл явц билээ. Дуунаас авсан ишлэл, цөлжилтийн шалтганыг тайлбарласан байдал, оновчгүй харьцууллыг авцалдаагүй ар араас залгасан — энэ бүхэн дээрх өгүүллийн эхлэлийн эрч хүчийг сааруулж байна. Экологийн нийтлэлд чамирах болдоггүй, улс төржиж болдоггүйг энэ жишээ тод харуулна.

«...Их холдоо 100 жилийн дараа Монгол оронд хүн амьдрах нөхцөлгүй цөлжилт үүсгэх үү, эсвэл тариа тарихаа яаралтай зогсоох уу гэсэн хоёр шийдлийн зааг дээр ирчихээд байна» (Монгол орноо цөлжилтөөс аваръя, «Өдрийн сонин», 2003.04.21) гэсэн өгүүлбэрийг уншихад зохиогчийн санаа тов тодорхой. Монголчууд тариа тариалсаар байх юм бол Монгол орон тэр чигтээ цөл болж хувирна, тариалахаа больчихвол цөлжилтөөс аврагдана. Гэтэл цөлжилт гээч тийм амар хялбар зүйл мөн үү?

Цөлжилтийг зогсоох, даван туулахын тулд түүнд хүргэж буй шалтгааныг үнэн зөв тогтоох шаардлагатай. Эс тэгвээс энэ нь салхин тээрэмтэй тулалдсанаас өөрцгүй юм.

Эцэст нь байгаль орчны сэдвийг тусгаж буй сэтгүүлчдээ шүүмжлэхийг урьтал болгосонгүй. Учир нь тэднийг ийм байхад нөхцөл байдал түлхэж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн чансаа экологийн сэдвийг тогтвортой, ул суурьтай тусгахад

багагүй үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг. Сонины чансаанаас экологийн орон тооны сэтгүүлч байх эсэх хамаарна. Цөөн тооны сурвалжлагчтай сонины газарт байгаль орчны сэдвээр хэн нэгнийг дагнуулан ажиллуулах нь нэг ёсондоо «тансаглал» юм. Ялангуяа, долоо хоногт нэг удаа, хагас сард нэг удаа гэх зэрэг давтамжтай дугаар нь гардаг сонин бол бараг л сул цалинжуулна гэсэн үг болно. Тиймээс ийм сонинд экологийн сэдвийг тусгах шаардлага гарвал хэн нэг одоос ярилцлага авахуулах гэж буй мэт тэр мөчид аль завтай, ажил багатай сэтгүүлчээ илгээдэг. Мэдээж, ийм тохиолдолд экологийн асуудлын олон сонирхолтой тал мэргэшээгүй сэтгүүлчийн хараа дуранд өртөлгүй өнгөрөх нь элбэг. Олон хувиар өдөр тутам хэвлэгддэг сонины хувьд байдал өөр юм. Энэ нь санхүүгийн тал дээр бэрхшээлгүй, нэг хүнийг цалинжуулахад гар татах зүйлгүй гэсэн үг. Дэлхийн бараг бүх томоохон сонин орон тооны экологийн сэтгүүлчтэй байдаг. Бээжинд хэвлэгддэг «Хятадын экологийн мэдээ» сонинд экологийн хэд хэдэн мэргэшсэн сэтгүүлч ажилладаг байна. Манай өдөр тутмын хэвлэлийн хувьд гэвэл экологийн сэдвээр дагнан мэргэшсэн чадварлаг сэтгүүлч Б.Батбилиг, Ж.Цэвээнхэрлэн нарын цөөн сэтгүүлч энэ сэдвийг зүрх сэтгэлийнхээ дуудлагаар сөхдөг.

Ишлэл

¹ Ариун Л. 2008. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ., 87 дахь тал.

² Куханова Л. А. Экологический PR: составные профессии. М., 2004, с. 158.

³ <http://baigal-orchin.mn>

⁴ <http://nomadgreen.org/archives/2011/04/17/11629/>

⁵ Успехи Китая в борьбе с опустыниванием. Агентство Синьхуа // http://www.russian.xinhuanet.com/russian/2008-06/17/content_653468.htm

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ариун Л. 2008. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ.
2. Берлова О. 1998. Некоторые аспекты экологических публичных отношений в России. Tasis.
3. Вингард Ж. Р., Одгэрэл П. 2001. Монголын байгаль орчны хууль тогтоомж: онол практик. УБ.
4. Коханова Л. А. 1997. Журналистика. Экология. Образование. М.
5. Коханова Л. А. 2004. Экологический PR: составные профессии. М.
6. Фридман Ш. М., Фридман К. А. 1998. Пособие по экологической журналистике. Tasis.
7. Burkett W. 1986. News Reporting: Science, Medicine and High Technology. The Iowa State University Press: Ames, Iowa.

8. Froster J. 1963. Science Writers Guide. Columbia University Press: N. Y.

Резюме

В настоящей статье автор, опираясь на многочисленные публикации ежедневной прессы на экологическую тему, в частности на тему опустынивания, анализирует мастерство газетных выступлений журналистов-экологов. При этом автор подвергает критике такие негативные стороны публикаций, как недостаточная разработанность темы, игнорирование мер, предпринимаемых правительством или различными организациями для преодоления существующей проблемы, поверхностное, дилетантское отношение к теме и т. д.